

## Хувилбар С

## Нэгдүгээр хэсэг

1. Монгол орны томоохон талуудын нэг болох Гурвансайханы арын тал ямар гарал үүсэлтэй вэ? /1 оноо/  
 А. хуримтлалын В. нуурын С. аллювийн D. делювийн Е. морены
2. 1921 оны өмнөх засаг захиргааны хуваарийг харуулсан дараах зурагт 3-ын тоогоор ямар аймгийг тэмдэглэсэн байна вэ? /1 оноо/



- А. Засагт хан аймаг В. Сайн ноён хан аймаг С. Түшээт хан аймаг  
 D. Сэцэн хан аймаг E. Ховдын хязгаар

3. Тэгш хэвтээ байрлалтай чулуулгийн үе давхаргууд тектоник хөдөлгөөний нөлөөгөөр атирааждаг. Атирааны гүдгэр хэсгийг юу гэдэг вэ? /1 оноо/  
 А. Горст В. Антиклиналь С. Грабен D. Синклиналь E. Геосинклиналь


4. Дараах химийн нэгдлүүдээс аль нь фотосинтезийн үйл явцын үр дүнд үүсдэг вэ? /1 оноо/  
 А. O<sub>2</sub> В. NaF С. SO<sub>2</sub> D. NO<sub>3</sub> E. C<sub>8</sub>H<sub>18</sub>

5. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу? /1 оноо/

.....газарзүйн уртраг гэнэ.

- А. Анхны голдчоос тухайн цэг хүртэлх зэргэдийн нумын өнцгийг  
 В. Анхны голдчоос баруун зүүн тийш байрлах газарзүйн байрлалыг  
 С. Анхны голдчоос баруун, зүүн тийш зэргэдийн нумын өнцгөөр тодорхойлогдсон газарзүйн байрлалыг  
 D. Экватороос тодорхой цэгт орших цэгийн нумын градусыг  
 E. Дэлхийн төвийг дайруулан татсан шугамыг

6. Дараах бүдүүвчийн асуултын тэмдгийн оронд тохирох үг юу вэ? /1 оноо/



- А. Хүмүүн капитал В. Ажилгүйчүүд С. Эдийн засгийн идэвхитэй хүн ам  
 D. Хүн амын цонх үе E. Хөдөлмөр эрхлэлт

7. Өөрийн тодорхой нэр, эзэмшсэн газар нутагтай, хэл, соёл, сэтгэлзүйн онцлог, зан заншил, уламжлалаар холбогдсон хүмүүсийн нийтлэгийг .....гэнэ. /1 оноо/

- А. үндэстэн В. угсаатны нийтлэг С. омог D. ястан E. түрэг хэлтэн

8. Холын зайг бага хугацаанд туулж, цаг хожих боломжтой байдаг ч үнэ өртөг ихтэй зэргээр бусад тээврээс ялгаатай тээврийн төрөл юу вэ? /1 оноо/

- A. Авто замын тээвэр                      В. Агаарын тээвэр                      С. Төмөр замын тээвэр  
D. Усан замын тээвэр                      Е. Дамжуулах хоолойн тээвэр

9. Монгол орны Газарзүйн шинжлэх ухааны нэрт эрдэмтэн Д.Базаргүрийн судалгааны чиглэл, голлох бүтээл юу вэ? /1 оноо/

- A. Физик газарзүй, Монгол орны физик газарзүй  
B. Нийгэм эдийн засгийн газарзүй, БНМАУ-ын нийгэм эдийн засгийн газарзүй  
C. Мал аж ахуйн газарзүй, Бэлчээрийн мал аж ахуйн газарзүй  
D. Ус зүй, палеонтологи, Монгол орны агуй, рашаан  
E. Ландшафт судлал, Дорнод Хангайн структур геоморфологийн онцлог

10. Дараах зурагт 1-ын тоогоор юуг тэмдэглэсэн байна вэ? /1 оноо/



- A. Камчаткийн хойг                      В. Гвинейн булан                      С. Бискайн булан  
D. Мексикийн булан                      Е. Сидра булан

11. Дараах хариултуудад шинэхэн цас, элс, ой мод, хар шорооны альбедо болон дэлхийн нийт альбедог өгчээ. Аль нь ой модны альбедо вэ? /1 оноо/

- A. 25                      В. 8                      С. 30                      D. 85                      Е. 4

12. Дараах зурагт Монгол орны хамгийн гүн нуур оршдог аймгийг хэдийн тоогоор тэмдэглэсэн байна вэ? /1 оноо/



- A. 5                      В. 4                      С. 2                      D. 3                      Е. 1

13. Энэтхэгийн далайн хамгийн гүн хонхор аль нь вэ? /1 оноо/

- A. Марианы хонхор /11022 м гүн/
- B. Пуэрто-Рико /8742 м гүн/
- C. Зондын хонхор /7729 м гүн/
- D. Гренландын тэнгис /5527 м гүн/
- E. Сөнөсөн тэнгис /395 м гүн/

14. Говьсүмбэр аймгийн Чойр хотоос урагш 20-иод км зайд орших.....орд нь 600 сая.тн хүрэн нүүрсний нөөцтэй. /1 оноо/

- A. Шивээ-Овоо
- B. Тавантолгой
- C. Багануур
- D. Шарын гол
- E. Зүүнбаян

15. Зурагт 2-ын тоогоор тэмдэглэсэн аймаг эдийн засгийн ямар бүсэд багтах вэ? /1 оноо/



- A. Баруун
- B. Зүүн
- C. Хангайн
- D. Төвийн
- E. Улаанбаатарын

16. Монгол орны баруун захын цэгээс зүүн захын цэг хүртэл хэдэн км байдаг вэ?

- A. 3485 км
- B. 4676,9 км
- C. 2392 км
- D. 1259 км
- E. 5145 км

17. Дараах корпорациудаас аль нь үндэстэн дамнасан корпораци вэ? /2 оноо/

- A. Mobicom
- B. Tavanbogd
- C. MGL
- D. Mogul
- E. Mc Donald's

18. Конусан тусгагийн уртраг нь нэг цэгээс цацарсан шулуун, өргөрөг нь..... хэлбэртэй байдаг. /2 оноо/

- A. нумарсан
- B. шулуун
- C. тойрог
- D. дөрвөлжин
- E. бөөрөнхий


19. Зуны хоёр сардаа бүрий ч болдоггүй, шөнө дунд ч нартай байх мөртлөө өвлийн хоёр сард нь огт нар үздэггүй Мурманск хотод очих хүсэлтэй хүн ямар улсад очих нь зөв бэ? /2 оноо/

- A. Словек
- B. Орос
- C. Молдав
- D. Австрали
- E. Кени

20. Агаарын чийгийг хэмжих бол аль багажийг ашиглах вэ? /1 оноо/

- A. Термометр
- B. Барометр
- C. Гигрометр
- D. Флюгер
- E. Луужин

21. Дараах зургийг ажиглаад асуултын тэмдгийн оронд тохирох хариултыг сонгоно уу? /2 оноо/



- A. 12-р сарын 6
- B. 147000000 км
- C. Өвлийн туйл
- D. Намрын өдөр шөнийн тэнцэл
- E. 1-р сарын 3

22. Дараах зурагт байгалийн ямар бүсийг үзүүлсэн бэ? /2 оноо/



- A. Хээрийн бүс
- B. Цөлийн
- C. Говийн бүс
- D. Ойт-хээрийн бүс
- E. Уулын босоо бүслүүр

23. Газар хөдлөлтийн дотоод голомтоос үүссэн хүч хаана хамгийн их байх вэ? /2 оноо/

- A. Дотоод төвд
- B. Завсарт
- C. Гадаад төвд
- D. Гүнд
- E. Голомтоос 100 км зайд

24. Арлын улсууд аль нь вэ? /2 оноо/

- A. Иран, Ирак
- B. Солонгос, Энэтхэг
- C. Афганистан, Узбекистан
- D. Шри-Ланк, Индонез
- E. Монгол, Филиппин

25. Нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ 5, 2-р байрт ордог аймгууд аль нь вэ? /2 оноо/

- A. Сүхбаатар, Баянхонгор
- B. Дорноговь, Говь-Алтай
- C. Өвөрхангай, Хэнтий
- D. Завхан, Ховд
- E. Өмнөговь, Дорнод

26. Улаанбаатар хотын нэрний өөрчлөлтийг хугацаатай нь зөв тохируулан бичсэн хариултыг сонгоно уу? /2 оноо/

- A. 1639 оноос Богдын өргөө
- B. 1924 оноос Улаанбаатар
- C. 1913 оноос Өргөө
- D. 1921 оноос Улаанбаатар
- E. 1911 оноос Да хүрээ

27. Монгол улсын одоогийн засаг захиргааны нэгжийг зөв гүйцээх үг юу вэ? /2 оноо/




- A. дүүрэг, хороо
- B. сум, баг
- C. баг, хороо
- D. дүүрэг, сум
- E. аймаг, баг

28. Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 5-аас дээш хувийг үйлдвэрлэж байгаа болон үйлдвэрлэх боломжтой ордуудыг стратегийн орд гэнэ. Тэгвэл дараах ордуудаас аль нь стратегийн ач холбогдол бүхий орд вэ? /2 оноо/

- A. Говь-Алтай аймаг - Зээгтийн нүүрсний орд
- B. Дорнод аймаг – Адуунчулууны нүүрсний орд
- C. Өмнөговь аймаг – Оюутолгойн зэс молибдены орд
- D. Хөвсгөл аймаг - Эгийн голын нүүрсний орд
- E. Увс аймаг - Хар тарвагатайн нүүрсний орд

29. Дараах зурагт 1 ба 2-ын тооны оронд бичигдэх төмөр замын өртөөний нэрийг олно уу? /2 оноо/



- A. 1-Улаанбатар, 2- Чойбалсан
- B. 1-Сайншанд, 2- Даланзадгад
- C. 1-Багануур, 2-Баруун урт
- D. 1-Салхит, 2- Зүүнбаян
- E. 1-Тавантолгой, 2- Дархан


30. Дэлхийн нефтийн гол бүс нутаг болдог бөгөөд нийслэл Эр-рияд хот нь цөл, хагас цөлийн бүсэд оршдог. Энэ хот ямар улсын нийслэл вэ? /2 оноо/

- A. Парагвай
- B. Эквадор
- C. Саудын араб
- D. Фижи
- E. Шинэ Зеланд

31. Дархан-Уул аймагт 2010 оны байдлаар 34100 ажиллагсад, 1641 бүртгэлтэй ажилгүйчүүд байсан бол ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхитэй хүн амыг олно уу? /2 оноо/

- A. 35741
- B. 44000
- C. 34100
- D. 1641
- E. 45824

32. Шашны ангилалыг зөв нөхөж гүйцээх хариулт аль нь вэ? /2 оноо/



- A. Сүннит, Шийт
- B. Шинто, Лам
- C. Күнз, Бөө мөргөл
- D. Үнэн алдартан, Католик
- E. Бага хөлгөн, Шарын

33. Хойд Европын улсууд аль нь вэ? /2 оноо/

- A. Австри, Бельги, Швейцар
- B. Швед, Норвеги, Финлянд
- C. Грек, Итали, Португал
- D. Румын, Чех, Унгар
- E. Украин, Гүрж, Югослав

34. Мах, сүүний чиглэлийн нутгийн шилмэл омгийн үхрийн үүлдэр аль нь вэ? /2 оноо/

- A. Уулын бор, Өнжүүл, Уулын алтай
- B. Баяд, Чамаар, Орхон
- C. Сэлэнгэ, Хар тарлан, Сементаль
- D. Гал шар, Тэс
- E. Галбын говийн улаан, Хэцийн хүрэн, Хос зогдорт

35. 10,5 сая км<sup>2</sup> талбайтай бөгөөд Гривничийн одон орон судлалын төв байдаг. Энэ тивийн хойд захын цэг Нордкин хошуу, урд захын цэг Рока хошуу х.ө 39<sup>0</sup>-т оршдог, ойролцоогоор 520 сая хүн амтай. Энэ ямар тив бэ? /2 оноо/

- A. Ази
- B. Америк
- C. Африк
- D. Австрали
- E. Европ

36. Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээ 1564116 км<sup>2</sup> ба 1963 онд 1017100 хүн амтай байсан бол хүн амын нягтшилыг олно уу? /2 оноо/

- A. 1,3
- B. 0,6
- C. 1,5
- D. 1,7
- E. 2,1

37. Дараах зурагт 3-ын тоогоор тэмдэглэсэн гадаргын усны ай савын үзүүлэлт аль нь вэ? /2 оноо/




- A. Нийт нутаг дэвсгэрийн -20%, урсацын-15%
- B. Нийт нутаг дэвсгэрийн -20%, урсацын-50%
- C. Нийт нутаг дэвсгэрийн -60%, урсацын-31%
- D. Нийт нутаг дэвсгэрийн -80%, урсацын-5%
- E. Нийт нутаг дэвсгэрийн -90%, урсацын-10%

38. Дараах хүснэгтэд өгөгдсөн уур амьсгалын нөхцөл бүхий газар нутаг хаана байж болох вэ? /2 оноо/

	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар	11-р сар	12-р сар
Температур /°C/	-50	-45	-32	-15	0	12	14	9	2	-15	-38	-48
Тунадас/ мм/	5	5	3	5	8	23	28	25	13	8	8	5


- A. Сомали улс
- B. Суматра арал
- C. Энэтхэг-Хятадын хойг
- D. Арктик
- E. Шри-ланк арал

39. Дараах зурагт аль тивийн ямар улсын нутаг дэвсгэрийг дүрсэлсэн байна вэ? /2 оноо/



- A. Ази тив-Афганистан улс
- B. Европ тив- Польш улс
- C. Ази тив- Сири улс
- D. Европ тив- Финлянд улс
- E. Ази тив- Хятад улс

40. Дараах зурагт 1 ба 2-ын тоогоор тэмдэглэсэн аймгуудын нэр болон цагийн бүсийн дугаарыг зөв харгалзуулсныг олоорой. /2 оноо/



- A. 1-Увс аймаг 6-р бүс, 2-Баянхонгор аймаг 8-р бүс
- B. 1-Баян-Өлгий 6-р бүс, 2-Өмнөговь аймаг 7-р бүс
- C. 1-Ховд аймаг 7-р бүс, Дорноговь аймаг 8-р бүс
- D. 1-Говь-Алтай аймаг 8-р бүс, Дундговь аймаг 6-р бүс
- E. 1-Завхан аймаг 6-р бүс, Өмнөговь аймаг 7-р бүс

41. Өөрийн тодорхой нэр, эзэмшил газар нутагтай, хэл, соёл, сэтгэл зүйн онцлог, зан заншил, уламжлалаар холбогдсон хүмүүсийн нийтлэгийг ястан гэдэг. 2000 оны байдлаар 103 мянга гаруй хүн амтай, Монгол улсын нийт хүн амын 4,3 %-ийг эзэлдэг нэгэн ястанг дараах зурагт харуулжээ. Энэ ямар ястан байна вэ? /2 оноо/

- A. Торгууд
- B. Үзэмчин
- C. Буриад
- D. Сартуул
- E. Казак



42. Дэлхийд ховор, манай улсад нэн ховор болсон Мөнххаргана нь байгалийн аль бүсэд ургадаг вэ? /2 оноо/



- A. Говь-цөлийн бүс
- B. Ойт хээрийн бүс
- C. Хээрийн бүс
- D. Ойн бүс
- E. Тайгын бүслүүр

43. Антрактидын тавцан болон Энэтхэг-Австралийн тавцангууд жилд 74 мм-ээр холдож байгаа гэж үзвэл 600000 жилийн дараа хоорондын зай нь одоогийнхоос хэдэн км холдох вэ? /2 оноо/

- A. 440000 км
- B. 45 км
- C. 44000 км
- D. 44,4 км
- E. 4400 км

44. Байгалийн бүс бүслүүр тус бүрт тархах хөрсний хэв шинжийг зөв харгалзуулна уу? /2 оноо/

Байгалийн бүс бүслүүр	Хөрсний хэв шинж
1. Экваторын ой	а. Чандруулаг
2. Сэрүүн бүсийн хээр	б. Улаан-шар, ферралит
3. Тайга	в. Хар шороон

- A. 1в, 2а, 3б
- B. 1а, 2б, 3в
- C. 1а, 2в, 3б
- D. 1б, 2а, 3в
- E. 1б, 2в, 3а

45. Дараах уул нуруудыг хойноос урагш зөв дараалуулсан нь аль нь вэ? /2 оноо/

- A. Байтаг богд, Түргэн, Шүдэн
- B. Лхачинвандад, Хөгнө хан, Цамбагарав
- C. Мөнхсарьдаг, Булнайн нуруу, Ээж хайрхан
- D. Бүтээлийн нуруу, Хөрх, Түргэн
- E. Таванбогд, Тарвагатайн нуруу, Асралт хайрхан


46. Дараах гол мөрдийг цутгах нууртай нь зөв харгалзуулсан хариултыг сонгоно уу? /2 оноо/

- 1. Ховд
- 2. Чоно харайх
- 3. Тэс
- а. Увс
- б. Хар-Ус нуур
- в. Хар нуур

- A. 1а, 2б, 3в
- B. 1б, 2в, 3а
- C. 1в, 2б, 3а
- D. 1а, 2в, 3б
- E. 1в, 2а, 3б




47. Дараах зурагт үзүүлснээр А-аас Б-рүү очсон жуулчин байгалийн ямар бүсээс ямар бүсэд очсон бэ? /2 оноо/



- A. Өргөн навчит мөнх ногоон ойн бүсээс цөл ба хагас цөлийн бүсэд
- B. Цөл ба хагас цөлийн бүсээс экваторын чийглэг ойн бүсэд
- C. Халуун орны хээрээс өндөр уулын бүсэд
- D. Хээрийн бүсээс цөлийн бүсэд
- E. Цөлийн бүсээс өндөр уулын бүсэд

48. Газрын гадаргын хэлбэр дүрс нь дотоод, гадаад олон хүчин зүйлүүдийн үйлчлэлээр үүсдэг. Дараах зурагт үзүүлсэн гадаргын хэлбэр ямар хүчин зүйлийн үйлчлэлээр үүссэн бэ? /2 оноо/



- A. Мөсөн гол
- B. Түр зуурын урсгал ус
- C. Гол мөрөн
- D. Галт уул
- E. Салхи

49. Тэнгисүүдийг орших далайтай нь тохируулна уу? /2 оноо/

- |                     |                           |
|---------------------|---------------------------|
| 1. Номхон далай     | a. Аравын тэнгис          |
| 2. Атлантын далай   | b. Карибын тэнгис         |
| 3. Энэтхэгийн далай | c. Дорнод Сибирийн тэнгис |
| 4. Хойд мөсөн далай | d. Агнуурын тэнгис        |

- A. 1a, 2c, 3d, 4b    B. 1c, 2b, 3a, 4d    C. 1b, 2d, 3c, 4a    D. 1d, 2b, 3a, 4c    E. 1b, 2a, 3d, 4c

50. Бархасвадь гаригийн нарнаас алслагдах зайг о.о.н ээр илэрхийлнэ үү? /2 оноо/

- A. 1,52    B. 0,72    C. 29,94    D. 5,18    E. 1

**Хоёрдугаар хэсэг.  
Тооцоолох даалгавар**

**Санамж:** Хоёрдугаар хэсэг нь тус бүр 4 оноотой 4 даалгавраас бүрдэнэ. Даалгаврын хариуг хариултын хуудасны хоёрдугаар хэсэгт дараах байдлаар бөглөхийг анхаарна уу?  
Жишээлбэл: Эцсийн хариу 5482 гэж гарсан бол a-5, b-4, c-8, d-2 гэж бөглөнө.

2.1. Монгол орны төв цэг болох Өвөрхөшөөтийн булгаас мэлхийн зам хүртэл шулуун зайгаар хэдэн км байх вэ?

2.2. 1 см-т 5 км нэрлэсэн масштабтай зураг дээр хоёр хотын хоорондын зай 6 см зурагдсан бол 1 см-т 2 км нэрлэсэн масштабтай зураг дээр хэдэн см зурагдах вэ?

2.3. Жижиг автобус 6-р сарын 15-ны өдөр 28 зорчигчтой Улаанбаатар хотоос хөдөлсөн ба нийт 1417 км зам туулж Увс аймагт очив. Зорчигч тээврийн эргэлт хэдэн хүн.км болохыг бодож олно уу?

2.4. Өргөргийн тойргийн урт 12576 км бол тухайн өргөрөг дээр орших газар нутгуудад дэлхийн тэнхлэгээ тойрон эргэх хөдөлгөөний улмаас үүсэх шугаман хурд хэдэн км/цаг байх вэ?